

ТАНИЛЦУУЛГА

2024 оны 1 дүгээр улирлын байдлаар Боловсрол, шинжлэх ухааны яам болон түүний харьяа байгууллагуудад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар

2024 оны 04 дүгээр сарын 04

Улаанбаатар хот

Иргэдээс төрийн захиргааны төв байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал тутам өссөн дүнгээр гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам (цаашид “БШУЯ” гэх) болон сайдад ажлаа шууд хариуцан тайлагнадаг харьяа байгууллагуудад 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 1236 өргөдөл, гомдол, хүсэлт ирүүлсэн байна.



Иргэдээс Боловсрол, шинжлэх ухааны яам болон албан тушаалтанд хандан 2024 оны 1 дүгээр улиралд нийт 1236 өргөдөл, гомдол ирүүлснээс 32% нь цахимаар, 57,8% нь бичгээр, 10,2% нь биечлэн уулзсан байна.

Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлыг төрлөөр нь ангилж үзвэл хүсэлт 1038 буюу 84%, санал 70 буюу 5,7%, гомдол 128 буюу 10,3% байна.



Хүснэгт. Ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга.

№	Тоо	Хувь	Өргөдөл гомдлын агуулга
1	207	16.8	Хууль эрх зүй, бодлого, үйл ажиллагааны чиглэлээр
2	445	36	Лавлагаа, бүртгэлийн чиглэлээр
3	244	19.7	Оюутны зээл, тусламж, тэтгэлгийн чиглэлээр
4	185	15	Төрийн албан хаагчийн ёс зүй, хүний нөөцийн чиглэлээр
5	155	12.5	Санхүүжилт, нийгмийн баталгааны чиглэлээр

Шийдвэрлэлт:

2024 оны 1 дүгээр улиралд ирүүлсэн 1236 өргөдөл, санал, хүсэлтийн 1151 буюу 93,1 хувийг шийдвэрлэсэн дүнтэй байна. Шийдвэрлэгдээгүй 85 өргөдөл хугацаандаа судлагдаж байна.

Цаашид:

- Эрхэлсэн асуудлын чиглэлээр боловсруулах хууль тогтоомж, дүрэм, журам болон яамнаас баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаандаа иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд агуулагдсан санал, санаачилгыг тусгахад анхаарна.
- Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхэд иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн үзүүлэлтийг харгалзан ажиллана.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ